

ХАСБАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ ТАЙЛАН

[Нираж Вэдва]

2023 оны 1 дүгээр улирал



МЭДЭГДЭЛ

ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн Хараат бус гишүүн Нираж Вэдва миний бие: (i) Компанийн тухай хууль (“КтХ”), Банкны тухай хууль (“БтХ”); (ii) Монголбанкны холбогдох журмууд болох “Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт шалгалтын журам” (“Засаглалын хяналт шалгалтын журам”), “Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам” (“Хараат бус гишүүний журам”); (iii) ХасБанкны Дүрэм болон бусад холбогдох засаглалын бодлого, зарчмын дагуу энэхүү Хараат бус гишүүний тайлан (“Тайлан”)-г бэлтгэсэн болно.

Тайлан нь дараах хугацааг хамарна: [2023 оны 1 дүгээр улирал] (“Тайлант хугацаа”).

1.ОРОЛЦООНЫ ТАЙЛАГНАЛ

(Хараат бус гишүүний журмын 5 дугаар зүйлийн 5.2.1 болон 5.2.2 дахь заалт)

Тайлант хугацаанд Хүснэгт 1-д заасан дараах хурлуудад оролцож ажиллалаа.

Хамрах хугацаан дахь ТУЗ-ийн хурлууд

Хүснэгт 1

Хурлууд	Оролцсон байдал	Огноо
ТУЗ-ийн хурал	Хараат бус гишүүнээр	2023.01.09 2023.01.11 2023.02.16 2023.02.23 2023.03.03 2023.03.14-15
ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны хурал	Гишүүнээр	2023.02.23 2023.03.14
ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны хурал	Гишүүнээр	2023.03.14
ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх цалин урамшууллын хорооны хурал	Ажиглагчаар	2023.02.23 2023.03.14
Хувьцаа эзэмшигчдийн хурал	Хараат бус гишүүнээр/Ажиглагчаар	2023.02.02 2023.03.27

ТУЗ-ийн хурал [хурлууд]

- ТУЗ-ийн ээлжит хурал [2023 оны 02 дугаар сарын 23]-ны өдөр дараах асуудлуудыг хэлэлцэж, хуралдав. Үүнд:

1. ТУЗ-ийн дэргэдэх Хороодын тайлан:

(1.1) Засаглал, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хороо:

(a) 2022 оны ажлын гүйцэтгэлд суурилсан урамшууллын сан;

(b) Гүйцэтгэх захирлын 2022 оны гүйцэтгэлийн үнэлгээ болон урамшуулал;

- (c) ТУЗ-ийн даргын гүйцэтгэлийн үнэлгээ болон урамшуулал;
- (d) 2022 оны гүйцэтгэлээрх хувьцааны үнэд суурилсан урамшуулал;

(1.2) Аудитын хороо:

- (a) ХасБанкны 2022 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлан;
2. Эми Чойг ТУЗ-д нэр дэвшүүлэх тухай (МБ-аас зөвшөөрөл авсан);
 3. 2022 оны жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан;
 4. 2022 оны ногдол ашгийн тухай шийдвэр;
 5. IPO үнэлгээний 5 жилийн төсөөлөл;
 6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2023 оны 4 дүгээр сарын 05-ны өдөр зарлах (IPO хийхтэй холбогдуулан); мөн
 8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2023 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр зарлах (жил бүрийн тогтмол хурал).

2022 оны жилийн эцсийн аудитлагдсан санхүүгийн тайлан, хувьцааны үнэд суурилсан урамшуулал, гүйцэтгэлийн үнэлгээ, ногдол ашиг, нийтэд санал болгон гаргах хувьцаа (IPO)-ны үнэлгээний 5 жилийн төсөөлөл болон 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс өмнө IPO хийх шаардлага гэх мэт асуудлаар үр дүнтэй хэлэлцүүлэг хийсэн. Би IPO-г хуулийн хугацаанд амжилттай хийж дуусгахыг дэмжсэн. Хараат бус гишүүд Монголбанктай хийсэн уулзалтын үеэр ч энэ тухай мэдэгдсэн.

- **ТУЗ-ийн ээлжит хурал [2023 оны 3 дугаар сарын 14, 15]-ийн өдөр дараах асуудлуудыг хэлэлцэж, хуралдав. Үүнд:**

1. ТУЗ-ийн дэргэдэх Хороодын тайлан:
 - 1.1 Эрсдэлийн Удирдлагын хороо:
 - (a) Монголбанкны шинэчилсэн журмын дагуу 2023 оны тогтворжуулах төлөвлөгөө;
 - (b) Нэгдмэл сонирхолтой этгээд/Сонирхлын зөрчилтэй хэлцлийг баталгаажуулах;
2. IPO хийхтэй холбогдуулан гадны хуулийн зөвлөхийн санал, дүгнэлт;
3. ХасБанкны ногдол ашгийн бодлого;
4. Андеррайтерын хараат бус хяналтын захидал;
5. IPO үнэ (үнэлгээ) & БДО тайлан;
6. IPO хуваарилалт (Стратегийн ба жижиглэн худалдаа);
7. IPO танилцуулга; мөн
8. Өргөдлийн маягтууд (IPO танилцуулгын хавсралт).

ХасБанкны ногдол ашгийн бодлого, ХасБанкны тогтворжуулах төлөвлөгөө, БДО-ийн тайланд үндэслэсэн IPO үнэлгээ, IPO танилцуулга болон IPO хуваарилалт (стратегийн хөрөнгө оруулагчид болон олон нийтэд) –ын талаар тус бүр үр дүнтэй хэлэлцүүлэг өрнүүлж, санал нэгдсэн. Эдгээр хэлэлцсэн асуудалд миний зүгээс санал нийлээгүй зүйл байгаагүй.

ТУЗ-ийн ээлжит бус хурал [01 дүгээр сарын 09]-ийн өдөр дараах асуудлуудыг хэлэлцэж, хуралдав. Үүнд:

1. Толгой компанитай нэгтгэхийн өмнө хувьцаа нийтэд санал болгож компанийг ХК хэлбэрээр өөрчлөн байгуулах асуудал;
2. Хувьцаа нийтэд санал болгох асуудал; мөн
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлах тухай асуудал.

- **ТУЗ-ийн ээлжит бус хурал [01 дүгээр сарын 11]-ийн өдөр дараах асуудлуудыг хэлэлцэж, хуралдав. Үүнд:**

1. Толгой компанитай нэгтгэхийн өмнө хувьцаа нийтэд санал болгож компанийг ХК хэлбэрээр өөрчлөн байгуулах асуудал;
2. Хувьцаа нийтэд санал болгох асуудал; мөн
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлах тухай асуудал.

Компанийн хуулийн хэлбэрийг өөрчлөн байгуулах, хувьцаа нийтэд санал болгох асуудлаар үр дүнтэй хэлэлцүүлэг өрнүүлж, санал нэгдсэн. Миний хувьд санал зөрөлдсөн зүйл байгаагүй.

- **ТУЗ-ийн ээлжит бус хурал [3 дугаар сарын 03]-ийн өдөр дараах асуудлуудыг хэлэлцэж, хуралдав. Үүнд:**

1. Хувьцаа эзэмшигчийн хүсэлтээр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдөр зарлан хуралдуулах тухай.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдөр зарлан хуралдуулах тухай шийдвэрийг санал нэгтэй зөвшөөрсөн.

Мөн түүнчлэн Хүснэгт 2-т заасан дараах цахим санал хураалтын хурлуудад оролцсон.

Хамрах хугацаан дахь цахим санал хураалтын хурлууд

Хүснэгт 2

Хурлууд	Санал хураалт	Огноо
ТУЗ-ийн цахим санал хураалтын хурал	Банкны 2022 оны ашгаас ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр гаргах асуудал	[2023.02.16]
ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны цахим санал хураалтын хурал	[***]	
ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны цахим санал хураалтын хурал	[***]	

2. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ БА ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЛИЙН ТАЙЛАН

(БтХ-ийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг болон Хараат бус гишүүний журмын 5 дугаар зүйлийн 5.2.3 дахь заалт)

БтХ-ийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэгт Банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн нь сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлахад заавал оролцож, санал өгнө гэж заасан.

Тайлант хугацаанд ТУЗ-ийн хурлаар 1 сонирхлын зөрчилтэй хэлцэл батлагдсан бөгөөд энэхүү хэлцэлд саналаа өгч ажилласан. 2023 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар холбогдох этгээд болон сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах тухай шийдвэрийг гаргасан.

Сонирхлын зөрчилтэй хэлцлийг хянаж үзсэний дараа зөвшөөрсөн санал өгсөн.

ТУЗ-ийн гишүүдээс сонирхлын зөрчилтэй гишүүн байсан тохиолдолд тухайн гишүүн нь хурлын эхэнд ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ мэдэгдэж, хэлэлцсэн асуудалд санал өгөөгүй болохыг тэмдэглэж байна.

3. ЗАСАГЛАЛЫН ТАЙЛАН

(КтХ-ийн 79 дүгээр зүйлийн 79.3 дахь хэсэг, Хараат бус гишүүний журмын 5 дугаар зүйлийн 5.2.4 дахь заалт болон Засаглалын хяналт шалгалтын журмын 3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсэг)

Дээр дурдсан хууль тогтоомжоор Хараат бус гишүүн нь Банкны оролцогч талууд, түүний дотор Хувьцаа эзэмшигч, харилцагч, хадгаламж эзэмшигч болон банкны ажилтны эрх ашгийг хамгаалах үүднээс ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь Банкны эрх ашиг, сонирхолд нийцсэн эсэх, мөн үйл ажиллагаа нь хууль тогтоомж дүрэм журамд нийцсэн эсэхэд хяналт тавих эрхтэй.

Банкны засаглалыг дүгнэхэд, ХасБанк нь засаглалын баримтжуулсан бодлого болон хяналтын механизмыг хэрэгжүүлдэг маш сайн засаглалтай.

КтХ-ийн 79 дүгээр зүйлийн 79.3 дахь хэсэгт заасан арга хэмжээ	
<p>КтХ 79.3.1 болон Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.5</p> <p>(БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУУЛЬ ТОГТООМЖ, ДҮРЭМ, ЖУРМЫН НИЙЦЭЛ)</p>	<p>Тайлант хугацаанд нийцлийн хувьд зөрчил илрээгүй. Аудитын дүгнэлтэд зарим тохиолдлуудыг тэмдэглэж, тэдгээрийг цаашид засч залруулах, бууруулах арга хэмжээ авсан.</p> <p>ХасБанк нь Монгол Улсын хууль тогтоомж, Монголбанкны зохицуулалтуудыг бүрэн дагаж мөрддөг.</p>
<p>КтХ 79.3.2</p> <p>(БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ)</p>	<p>Би Компанийн тухай хуулийн 79.3.2 дэх хэсгийн дагуу ямар нэгэн зөрчлийг анзаараагүй.</p>

<p>КтХ 79.3.3</p> <p>(ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГУУЛАХ)</p>	<p>[2023 оны 02 дугаар сарын 02]-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон ба хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн асуултад хариулахад бэлэн байсан. ТУЗ-ийн хурлаар хэлэлцсэн асуудалд зарчмын зөрүүтэй байр суурь байгаагүй ба Хувьцаа эзэмшигчид мэдээлсэн зүйл байхгүй.</p> <p>[2023 оны 03 дугаар сарын 27]-ны Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон ба хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн асуултад хариулахад бэлэн байсан. ТУЗ-ийн хурлаар хэлэлцсэн асуудалд зарчмын зөрүүтэй байр суурь байгаагүй ба Хувьцаа эзэмшигчид мэдээлсэн зүйл байхгүй.</p>
<p>Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.1</p> <p>(ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ГАРГАСАН ШИЙДВЭР НЬ БАНКНЫ ЭРХ АШИГТ НИЙЦСЭН ЭСЭХ)</p>	<p>Би ХасБанкийг Монгол Улсын засаглалын болон хянан нийцүүлэлтийн стандартыг маш сайн дагаж мөрддөг гэдгийг баталж байна. ТУЗ болон удирдлагаас гаргасан бүх шийдвэр нь банкны эрх ашигт бүрэн нийцдэг.</p>
<p>Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.2</p> <p>(ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦСЭН ЭСЭХ)</p>	<p>ХасБанк нь засаглалын хамгийн өндөр стандартыг дагаж мөрддөг бөгөөд миний хувьд ямар нэгэн сөрөг зүйл ажиглагдаагүй болно.</p>
<p>Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.3</p> <p>(БАНКНЫ ХАРИЛЦАГЧ, ХАДГАЛАМЖ ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ)</p>	<p>ХасБанк нь засаглалын хамгийн өндөр стандартыг мөрддөг бөгөөд банкны харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрхийг хамгаалахын эсрэг ямар нэгэн зүйл ажиглагдаагүй.</p>
<p>Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.6</p> <p>(МОНГОЛБАНКИНД ЗӨРЧИЛ МЭДЭЭЛЭХ)</p>	<p>ХасБанк нь засаглалын хамгийн өндөр стандартыг мөрддөг бөгөөд миний ажиглалтаар ямар нэгэн зөрчил илрээгүй. Монголбанкны төлөөлөгчидтэй хийсэн Хараат бус гишүүдийн уулзалтын үеэр би компанийн бүтцийн хувьд Хувьцаа эзэмшигчид санал нэгдэх асуудал удааширсан болон IPO хойшилсон зэрэг асуудлыг онцолсон.</p>

	Өнөөдрийн байдлаар эдгээр бүх асуудал тохиролцоонд хүрч, ХасБанк 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор IPO хийхээр зорин ажиллаж байна.
--	--

4. БУСАД

Тайлант хугацаанд Би Банкны бусад Хараат бус гишүүдийн хамт Монголбанкны төлөөлөгчидтэй уулзаж, бид Хараат бус гишүүдийн үүрэг ролийн талаар ярилцаж, санал солилцсон.

ХасБанкны хувьд IPO хийхтэй холбоотойгоор энэ улирал маш чухал улирал байлаа. Би Хувьцаа эзэмшигчид бүтцийн өөрчлөлт болон IPO хийхтэй холбоотой асуудалд зөвшилцөлд хүрсэнд баяртай байна. ХасБанк санхүүгийн жилийн шилдэг гүйцэтгэлийг тайлагналаа. Мэргэжлийн ТУЗ, чадварлаг Гүйцэтгэх удирдлага, удирдлагын баг, ажилтнууд, хүчирхэг засаглал, дижитал хэрэглээ болон 5 жилийн тодорхойлсон зураглал (road map)-тай тус банк нь манлайлагч хэвээр үлдэж, цаашид Монголын ард түмэнд дижитал банкны үйлчилгээг үзүүлэхэд маш сайн байр суурьтай байна.

Огноо: 2023 оны 4 дүгээр сарын 12

Нираж Вэдва,
ХасБанкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн